



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН
ИХ СУРГУУЛЬ

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 он 09 сар 02 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Тус сургуулийн холбогдох журам, Захиргааны зөвлөлийн 2021 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн "2+2 хөтөлбөрөөр оюутан суралцуулах журам"-ыг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү журмыг 2021-2022 оны хичээлийн жилийн 1-р улирлаас дагаж мөрдсүгэй.

3. Дээрх журамтай холбоотой хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сургалтын албаны дарга /Б.Оюун-Эрдэнэ/, гадаад харилцаа, оюутны албаны дарга /Ким Жэ Сон/, бүрэлдэхүүн сургуулийн захирал, тэнхимийн эрхлэгч, санхүүгийн хэлтсийн дарга /Э.Чулуунцэцэг/ нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбоотойгоор Ерөнхий захирлын 2019 оны 06-р сарын 18-ны өдрийн А/49 тоот тушаалын хавсралт "2+2 хөтөлбөрөөр оюутан суралцуулах журам"-ыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ-г

ЧОЙ ГИ ХО



ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН ИХ СУРГУУЛИЙН “2+2” ХӨТӨЛБӨРӨӨР ОЮУТАН СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль болон сургалтын үйл ажиллагаа явуулахад холбогдох хууль эрх зүйн баримт бичгүүд, тэдгээрт нийцүүлэн удирдах дээд байгууллагаас гаргасан эрх зүйн бичиг баримт, сургуулийн дотоод дүрэм, журмыг үндэслэн ОУУБИС-ийн 2+2 хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- 1.2 Зорилго нь ОУУБИС болон гадаадын их сургууль хамтран “2+2” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиг баримжаа болоход оршино.
- 1.3 Хамтын ажиллагаатай сургуулиудтай шинээр гэрээ байгуулах, эсвэл гэрээний хугацаа дуусаж хүчингүй болох тохиолдолд энэ журмын хавсралтыг шинэчлэн өөрчилдөг байна.
- 1.4 “2+2” хөтөлбөрт хамрагдан суралцагч нь журамд заасан шаардлагыг бүрэн хангасан бол ОУУБИС, гадаадын их сургуулийн бакалаврын зэргийн дипломыг авах боломжтой.
- 1.5 Гэрээгээр суралцах оюутан эх орон, ОУУБИС-ийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, хичээл зүтгэлтэй, үнэнч шударга, хариуцлагатай суралцана.
- 1.6 Журамд хэрэглэсэн нэр томьёо, түүний тайлбар:
 - 1.6.1 Гэрээт сургууль: ОУУБИС-тай “2+2” хөтөлбөрөөр оюутан суралцуулах гэрээ байгуулсан гадаадын их сургууль.
 - 1.6.2 Гэрээт оюутан: “2+2” хөтөлбөрийн болзлыг хангаж, гэрээт сургуулиас зөвшөөрсөн оюутан.

Хоёр. “2+2” хөтөлбөрөөр суралцах оюутанд тавигдах шаардлага

- 2.1 Гэрээт оюутан ОУУБИС-ийн элсэлтийн журмын дагуу мэргэжлийн тодорхой хөтөлбөрийг сонгон элссэн суралцагч байна.
- 2.2 Гэрээт оюутан ОУУБИС-ийн “2+2” хөтөлбөрийн журам, гэрээт сургуулийн шаардлага, холбогдох хөтөлбөрүүдийг судалж өөрөө болон түүний ар гэрийнхэн зөвшөөрсөн тохиолдолд холбогдох нэгжид хүсэлтээ гаргана.
- 2.3 “2+2” хөтөлбөрт гэрээгээр суралцах оюутан элссэн хөтөлбөрийнхөө дагуу 4 улиралд ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээл 60-аас багагүй кредит судласан байна.

- 2.4 Гэрээт оюутан ОУУБИС-д суралцах хугацааны турш F үнэлгээ, W тэмдэглэгээ авахгүй байхын зэрэгцээ нийт үнэлгээний голч (ҮГД) нь 2,5-аас дээш байна.
- 2.5 "2+2" хөтөлбөрт хамрагдсан оюутан 2 жилийн хугацаанд жилийн чөлөө авахгүй, тасралтгүй суралцсан байна.
- 2.6 2+2 хөтөлбөрт хамрагдах оюутан суралцах хугацаандаа ОУУБИС-ийн бусад дүрэм журмыг чандлан баримталж, ямар нэгэн ёс зүй, сахилгын зөрчил гаргаагүй байна.
- 2.7 Гэрээт оюутан ОУУБИС-д 3 улирал суралцах хугацаандаа гэрээний 3.4, 3.5 дугаар заалтын дагуу гадаад хэлний шалгалт өгч гэрээт сургуулиас тавигдсан шаардлагад тэнцсэн байна.

Гурав. Мэргэжил сонгох, суралцах тухай

- 3.1 Ижил мэргэжлээр (хөтөлбөр) гэрээт сургуульд суралцах, эсвэл өөр мэргэжлийг гэрээт сургуулиас сонгон суралцаж болно.
- 3.2 Оюутан гэрээт сургууль, мэргэжил сонгосон хүсэлтээ 3-р улиралд гаргах бөгөөд шаардлага хангасан оюутан 4 улирал суралцсаны дараа сургуульд суралцахаар явна.
- 3.3 Мэргэжил сольж гэрээт сургуульд суралцах оюутанд ОУУБИС-ийн диплом олгох боломжгүй бөгөөд бакалаврын зэргийн диплом авахыг хүсвэл зэрэг олгоход тавигдах шаардлагын дагуу зөрүү кредит судална.
- 3.4 Гэрээгээр суралцах оюутан ОУУБИС-д үндсэн хөтөлбөрөөс гадна гадаад хэл эзэмшүүлэх тусгай сургалтад заавал суралцана.
- 3.5 Гадаад хэлний сургалтад суралцаж байгаа оюутан жилд хоёроос доошгүй удаа олон улсын хэмжээнд явагддаг түвшин тогтоох албан ёсны шалгалтыг өгнө.
- 3.6 Гэрээт сургуульд суралцах оюутан, түүний гэр бүлийн төлөөлөгч, ОУУБИС-тай 2+2 хөтөлбөрийн гэрээ байгуулна.

Дөрөв: Гэрээт сургуульд судалсан хичээлийг тооцох, диплом олгох

- 4.1 Гэрээт сургуульд суралцаж байгаа оюутан сурлагын дүнгээ ОУУБИС-ийн Сургалтын албанд улирал тутам ирүүлнэ.
- 4.2 Судалсан хичээл, дүн нь оюутны дүнгийн хуудсанд нэмэгдсэнээр сургалтын албанаас тодорхойлолтыг оюутны ар гэрийнхэнд мэдэгдэж байна.

4.3 Гэрээт оюутан сурлагын дүнгээ цаг тухайд нь ирүүлээгүй тохиолдолд судалсан хичээлийн жагсаалтыг шинэчлэхгүй, улмаар сургуулийн диплом олгохгүй.

4.4 ОУУБИС нь "2+2" хөтөлбөрийн дагуу гэрээт сургуулиас олгосон дипломыг үндэслэн өөрийн сургуулийн дипломыг олгохын тулд дараах шаардлагыг тавина. Үүнд:

4.4.1 Гэрээт сургуульд 4 улирал суралцах хугацаанд төлөвлөгөөнд заасан 60 кредитээс багагүй хичээлийг судалсан байна.

4.4.2 Гэрээт сургуульд судалсан хичээлүүдийн нийт голч дүн нь 2.0-оос дээш байна.

Тав: Сургалтын төлбөр, бусад зардал

5.1 "2+2" хөтөлбөрт хамрагдах зорилгоор суралцаж байгаа оюутны ОУУБИС-ын сургалтын төлбөр нь үндсэн оюутны төлбөртэй адил байна.

5.2 Гадаад хэл эзэмшүүлэх тусгай сургалтын төлбөрийг сургалтын төлбөрөөс тусдаа тооцож төлнө.

5.3 Гадаад хэлний тусгай сургалтын төлбөрийг нэг долоо хоног хичээл сонссон тохиолдолд буцаан олгохгүй болно.

5.4 Гадаадын их сургуульд үргэлжлүүлэн суралцах үед тухайн улсын сургуулийн сургалтын төлбөр, оюутны байр, ном сурах бичиг, унаа, эрүүл мэндийн даатгал, хувийн хэрэгцээний зардлаа оюутан өөрөө хариуцна.

5.5 Гадаадын их сургуулийг төгссөний дараа, эсвэл тодорхой шалтгаанаар буцан ирж ОУУБИС-ийн диплом авах зорилгоор үргэлжлүүлэн суралцах үедээ зөрүү кредитын төлбөрийг төлнө.